



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2015 оны 06 сарын 26 өдөр

Дугаар А/59

Чингис

Зардал гаргах тухай

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Нийгмийн хэв журам хамгаалах /код 400/ журам”-ын код 400.5.1.а дахь заалт, “Байгууллагын даргын тушаал гаргах /код 136/ журам”-ын 136.4.2-ын “е” дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Аймгийн Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор зохион байгуулагдаж буй “Бурхан Халдун уулын тахилга”-ын арга хэмжээний ёслол, хамгаалалтыг аймгийн Засаг даргын тамгын газартай хамтран төлөвлөгөө, удирдамжийн дагуу зохион байгуулахыг нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Д.Батхүү, төлөвлөлт, зохион байгуулалтын тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Д.Дэлэг нарт даалгасугай.

2. Тахилгын арга хэмжээний зардлын шатахуунд 1000000 сая /нэг сая/ төгрөг, хүнсэнд 1000000 сая /нэг сая/ төгрөг, нийт 2000000 сая /хоёр сая/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс шийдвэрлүүлж, алба хаагчдын хоолны зардалд туслах аж ахуйгаас 1 /нэг/ хонь, 2 /хоёр/ ямаа, нийт 3 /гурван/ толгой мал олгож зарлагадахыг ахлах нягтлан бодогч, цагдаагийн хошууч Ж.Баатарт зөвшөөрсүгэй.

3. Тушаалыг бүрэлдэхүүнд танилцуулсугай.

ДАРГА ЦАГДААГИЙН  
ХУРАНДАА

П.ОРОСТОГОО

